



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гаалийн ерөнхий газрын харьяа Ханги дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2026/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дорноговь аймаг 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Аудитор:	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Б.Ариунбаатар Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
5.Аудитын илрүүлэлт.....	9
5.1 Залруулсан алдаа .....	9
5.2 Өгсөн зөвлөмж .....	9
6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	10

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,  
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

№ 2026.02.10 № 1-6/49

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА  
ХАНГИ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.ЦОЛБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гаалийн ерөнхий газрын харьяа Ханги дахь гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гаалийн ерөнхий газрын харьяа Ханги дахь гаалийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлыг онцолсон хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

### Аудитын гол асуудал

Завсрын аудитаар байгууллагын 3 дугаар улирлын үндсэн хөрөнгийн үлдэгдэлд биет тооллого явуулахад 15 нэр төрлийн 24 ширхэг тавилга, эд хогшил болон тоног төхөөрөмж бүртгэлгүй байсныг бүртгэлд тусгуулах зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулсан.

### Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

442505027

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР \_\_\_\_\_ Т.ГАН-ӨЛЗИЙ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>57,657,200.27</u></b>	<b><u>86,689,108.38</u></b>
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	57,657,200.27	86,689,108.38
354	<b>Хангамжийн материал</b>	57,657,200.27	86,689,108.38
35410	Бичиг хэргийн материал	707,200.00	477,600.00
35420	Аж ахуйн материал	30,691,922.58	30,104,030.27
35470	Бусад хангамжийн материал	26,258,077.69	56,107,478.11
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>5,183,601,563.30</u></b>	<b><u>6,821,338,889.09</u></b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,183,601,563.30	6,821,338,889.09
392	<b>Биет хөрөнгө</b>	4,783,686,050.30	6,448,907,408.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,572,074,128.95	5,328,439,798.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(951,721,995.93)	(1,057,021,174.27)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	368,800,000.00	368,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(155,984,427.50)	(193,566,666.72)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,286,257,608.08	2,677,240,787.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(456,814,263.30)	(777,917,277.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	136,015,522.00	133,563,842.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,940,522.00)	(30,631,902.00)
393	<b>Биет бус хөрөнгө</b>	399,915,513.00	372,431,480.90
39301	Програм хангамж	60,311,513.00	60,311,513.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(396,000.00)	(27,880,032.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	340,000,000.00	340,000,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>5,241,258,763.57</u></b>	<b><u>6,908,027,997.47</u></b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b><u>984,680,012.99</u></b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	984,680,012.99
413	<b>Өглөг</b>	-	984,680,012.99
4136	<b>Бусад өглөг</b>	-	984,680,012.99
41361	Байгууллагад төлөх өглөг	-	984,680,012.99
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>10,482,517,528.43</u></b>	<b><u>5,923,347,984.48</u></b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	10,482,517,528.43	5,923,347,984.48
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	10,482,517,528.43	5,923,347,984.48
51210	Өмнөх үеийн үр дүн	5,241,258,763.57	5,226,742,807.23
51220	Тайлант үеийн үр дүн	5,241,258,764.86	696,605,177.25
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>10,482,517,528.43</u></b>	<b><u>6,908,027,997.47</u></b>

### Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>7,370,930,346.14</b>	<b>3,722,588,958.94</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,396,584,842.14</b>	<b>489,302,605.71</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,396,584,842.14	489,302,605.71
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,396,584,842.14	462,616,948.70
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,800,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	73,794,790.08	18,565,100.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	5,322,790,052.06	433,251,848.7
120009	Бусад орлого	-	26,685,657.01
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,974,345,504.00</b>	<b>3,233,286,353.23</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,974,345,504.00	3,233,286,353.23
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,974,345,504.00	3,233,286,353.23
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,129,671,582.57</b>	<b>3,004,612,116.05</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,129,671,582.57</b>	<b>3,004,612,116.05</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,625,847,123.67	2,905,780,768.18
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	931,921,000.71	1,917,362,389.17
210101	Үндсэн цалин	345,905,209.83	895,959,709.76

Гаалийн ерөнхий газрын харьяа Ханги дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

210102	Нэмэгдэл	332,964,743.41	541,706,522.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	136,375,000.00	288,375,000.00
210104	Урамшуулал	116,676,047.47	191,321,156.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>117,376,189.04</b>	<b>237,802,926.88</b>
210201	Тэтгэврийн даатгал	79,125,187.73	160,272,646.74
210202	Тэтгэмжийн даатгал	9,308,845.82	19,112,532.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,792,745.83	11,631,437.10
210204	Ажилгүйдлийн даатгал	4,629,881.81	9,357,262.09
210205	Эрүүл мэндийн даатгал	18,519,527.85	37,429,048.41
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,242,135.35</b>	<b>121,984,831.21</b>
210301	Гэрэл, цахилгаан	54,142,135.35	101,593,742.05
210302	Түлш, халаалт	8,100,000.00	20,391,089.16
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,264,143.00</b>	<b>20,471,600.31</b>
210401	Бичиг хэрэг	2,911,183.33	2,301,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,800,000.00	15,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		344,108.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,552,959.67	2,226,392.31
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>325,400.00</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	325,400.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>268,336,700.00</b>	<b>54,163,817.65</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,771,000.00	6,476,162.05
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	342,500.00	555,500.00
210604	Урсгал засвар	258,223,200.00	47,132,155.60
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,405,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	2,405,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48,787,216.81</b>	<b>37,947,632.03</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,369,535.00	20,263,653.23
210804	Тээврийн хэрэгслийн татвар		1,010,040.00
210807	Газрын төлбөр		301,828.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	32,417,681.81	16,372,110.80
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>174,189,338.76</b>	<b>516,047,570.93</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	174,189,338.76	516,047,570.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>503,824,458.90</b>	<b>98,831,347.87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>84,138,004.00</b>	<b>-</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,519,404.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	55,618,600.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>419,686,454.90</b>	<b>98,831,347.87</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	419,686,454.90	98,831,347.87
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>5,241,258,763.57</u></b>	<b><u>717,976,842.89</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>21,371,665.64</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		21,371,665.64
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(21,371,665.64)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>5,241,258,763.57</u></b>	<b><u>696,605,177.25</u></b>

Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,974,345,504.00</u></b>	<b><u>3,244,086,353.23</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>10,800,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>-</b>	<b>10,800,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,800,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,974,345,504.00</b>	<b>3,233,286,353.23</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,974,345,504.00</b>	<b>3,233,286,353.23</b>

Гаалийн ерөнхий газрын харьяа Ханги дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,974,345,504.00	3,233,286,353.23
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,974,345,504.00</b>	<b>3,244,086,353.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,974,345,504.00</b>	<b>3,244,086,353.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,470,521,045.10</b>	<b>3,145,255,005.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	931,921,000.34	1,921,796,880.70
210101	Үндсэн цалин	418,251,468.44	859,739,363.72
210102	Нэмэгдэл	259,314,526.22	582,372,210.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	136,327,852.95	287,559,150.20
210104	Урамшуулал	118,027,152.73	192,126,156.44
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	117,376,189.41	233,368,435.35
210201	Тэтгэврийн даатгал	79,125,187.53	152,466,366.46
210202	Тэтгэмжийн даатгал	9,308,846.69	38,248,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,792,745.73	7,208,553.79
210204	Ажилгүйдлийн даатгал	4,629,881.80	6,585,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,519,527.66	28,859,815.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	75,742,135.35	149,593,742.43
210301	Гэрэл, цахилгаан	54,142,135.35	101,593,742.05
210302	Түлш, халаалт	21,600,000.00	48,000,000.38
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,469,735.00	19,564,108.00
210401	Бичиг хэрэг	3,101,800.00	2,071,500.00
210402	Тээвэр, шатахуун	12,800,000.00	15,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	344,108.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,567,935.00	1,548,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	325,400.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	325,400.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	285,810,650.00	798,821,317.65
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,902,450.00	440,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	685,000.00	213,000.00
210604	Урсгал засвар	258,223,200.00	798,168,317.65
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,405,000.00	-
210702	Дотоод албан томилолт	2,405,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	35,470,935.00	22,110,521.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,369,535.00	20,353,653.23
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	1,010,040.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,817,400.00	-
210807	Газрын төлбөр	-	301,828.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	284,000.00	445,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>503,824,458.90</b>	<b>98,831,347.87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>503,824,458.90</b>	<b>98,831,347.87</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,519,404.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	55,618,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	419,686,454.90	98,831,347.87
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(14,515,956.34)	(14,515,956.34)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(14,515,956.34)	(14,515,956.34)
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-

Гаалийн ерөнхий газрын харьяа Ханги дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн			5,241,258,763.57	5,241,258,763.57
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>5,226,742,807.23</b>	5,226,742,807.23
D01	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>10,468,001,570.80</b>	5,226,742,807.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(14,515,956.34)	(14,515,956.34)
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>5,212,226,850.89</b>	5,212,226,850.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			696,605,177.25	696,605,177.25
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>5,908,832,028.14</b>	5,908,832,028.14

**Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	3,281,355,153.23	3,244,086,353.23	37,268,800.00	98.9
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3,281,355,153.23	3,244,086,353.23	37,268,800.00	98.9
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,281,355,153.23	3,145,255,005.36	136,100,147.87	95.9
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,987,028,600.00	1,921,796,880.70	65,231,719.30	96.7
210101	Үндсэн цалин	861,259,800.00	859,739,363.72	1,520,436.28	99.8
210102	Нэмэгдэл	592,206,200.00	582,372,210.34	9,833,989.66	98.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	333,825,800.00	287,559,150.20	46,266,649.80	86.1
210104	Урамшуулал	199,736,800.00	192,126,156.44	7,610,643.56	96.2
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	237,838,600.00	233,368,435.35	4,470,164.65	98.1
210201	Тэтгэврийн даатгал	160,336,800.00	152,466,366.46	7,870,433.54	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	38,248,500.00	38,248,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,541,700.00	7,208,553.79	(666,853.79)	110.2
210204	Ажилгүйдлийн даатгал	6,542,400.00	6,585,200.00	(42,800.00)	100.7
210205	Эрүүл мэндийн даатгал	26,169,200.00	28,859,815.10	(2,690,615.10)	110.3
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	191,942,400.00	149,593,742.43	42,348,657.57	77.9
210301	Гэрэл, цахилгаан	179,450,000.00	101,593,742.05	77,856,257.95	56.6
210302	Түлш, халаалт	12,492,400.00	48,000,000.38	(35,507,600.38)	384.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,081,200.00	19,564,108.00	2,517,092.00	88.6
210401	Бичиг хэрэг	2,992,100.00	2,071,500.00	920,600.00	69.2
210402	Тээвэр, шатахуун	15,700,000.00	15,600,000.00	100,000.00	99.4

Гаалийн ерөнхий газрын харьяа Ханги дахь гаалийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	995,800.00	344,108.00	651,692.00	34.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,393,300.00	1,548,500.00	844,800.00	64.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	9,954,300.00	-	9,954,300.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,954,300.00	-	9,954,300.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	799,490,300.00	798,821,317.65	668,982.35	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	440,000.00	440,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	844,900.00	213,000.00	631,900.00	25.2
210604	Урсгал засвар	798,205,400.00	798,168,317.65	37,082.35	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,260,000.00	-	7,260,000.00	-
210702	Дотоод албан томилолт	7,260,000.00	-	7,260,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	25,209,753.23	22,110,521.23	3,099,232.00	87.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,353,653.23	20,353,653.23	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,990,900.00	-	1,990,900.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,099,800.00	1,010,040.00	89,760.00	91.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	69,700.00	-	69,700.00	-
210807	Газрын төлбөр	699,100.00	301,828.00	397,272.00	43.2
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	996,600.00	445,000.00	551,600.00	44.7
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	550,000.00	-	550,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	550,000.00	-	550,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	98,831,347.87	(98,831,347.87)	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	98,831,347.87	(98,831,347.87)	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	98,831,347.87	(98,831,347.87)	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,281,355,153.23	3,244,086,353.23	37,268,800.00	98.9
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	3,281,355,153.23	3,233,286,353.23	48,068,800.00	98.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,281,355,153.23	3,233,286,353.23	48,068,800.00	98.5
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	10,800,000.00	(10,800,000.00)	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,800,000.00	(10,800,000.00)	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,119.8 сая төгрөгийн 5 алдаа илрүүлж аудитын явцад залруулсан.

### 5.1 Залруулсан алдаа

1. Завсрын аудитаар 3,168,855.3 төгрөгийн цалинг үр дүнгийн тайланд илүү бүртгэж тайлагнасан байна. Гүйцэтгэлийн үе шатанд дээрх алдаа давтагдан гараагүй байна.
2. Тус байгууллагын 3 дугаар улирлын дансны хуулгыг мөнгөн гүйлгээний журналтай тулгахад нийгмийн даатгалын ХЧТАТ-ийн 1,460,544 төгрөгийн орлогыг давхардуулан бүртгээсэн байна. Гүйцэтгэлийн үе шатанд дээрх алдаа давтагдан гараагүй байна.

### 5.2 Өгсөн зөвлөмж

#### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Завсрын аудитаар үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй 57,341,513 төгрөгийн 8 нэр төрлийн 41 программ хангамжийн лицензийг ашиглах жил оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Ерөнхий нягтлан бодогч нь холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээнэ”, УСНББОУС-31 Биет бус хөрөнгийн 7-д “Программ хангамж нь холбогдох техник хэрэгслийн салшгүй нэг бүрэлдэхүүн хэсэг биш байх тохиолдолд компьютерийн программ хангамжийг бие бус хөрөнгө гэж үзнэ”, 88-д “Биет бус хөрөнгийн нягтлан бодох бүртгэл нь түүний ашиглалтын хугацаанд үндэслэдэг. Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулна”, Сангийн Сайдын 2025 оны А/3 тушаалын хавсралтаар батлагдсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 11.12-т “Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхой бол түүний хорогдуулах дүнг ашиглалтын хугацаанд нь тодорхой аргаар хуваарилж, хорогдуулгын зардалд тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 57,341,513 төгрөгийн дансны үнэтэй 8 нэр төрлийн 41 программ хангамжийн лицензийн ашиглалтын хугацааг тогтоож холбогдох стандарт, журамд заасны дагуу хорогдуулах;*

1.2 Тус байгууллагын 3 дугаар улирлын үндсэн хөрөнгийн үлдэгдэлд биет тооллого явуулахад 15 нэр төрлийн 24 ширхэг тавилга эд хогшил болон тоног төхөөрөмж бүртгэлгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө, эд хөрөнгө дутагдсан үед заавал хийнэ”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах зөвлөлийн байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмын 5.4-т “Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон олж авсан хөрөнгө, төслийн шугамаар бий болсон эд хөрөнгийг бүртгэх бол хөрөнгийн чанар байдлыг нь харгалзан элэгдэл, хорогдлыг

нь тооцон ашиглах хугацааг тогтоож дүгнэлт гаргах талаар санал дүгнэлт гаргах, шийдвэрийг хэрэгжүүлнэ” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хавсралтад тусгасан данс бүртгэлд тусгаагүй 15 нэр төрлийн 24 хөрөнгийг холбогдох өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дансны үнэ болон ашиглах жилийг тогтоож данс бүртгэлд тусгах;

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлсийг илүү бүртгэж тайлагнасан	1	3,168.8			1	3,168.8	1	3,168.8				
Тайлант хугацааны орлогыг илүү бүртгэсэн	1	1,460.5			1	1,460.5	1	1,460.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>4,629.4</b>			<b>2</b>	<b>4,629.4</b>	<b>2</b>	<b>4,629.4</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдэл тооцоогүй	1	-					1	-
Биет тооллого явуулахад бүртгэлгүй хөрөнгө илрүүлсэн	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>					<b>2</b>	<b>-</b>